ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2024/156/НА-СТА-ТШЗ**

---


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Дундговь аймаг<br>2024 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Х.Наранцацрал<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК<br>Захирал: Х.Ариунзул<br>Утас: 99077062<br>Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-22 № 30

танай ______________ -ны № ______________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Х.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумынХүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.2 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэг 15 бүлэгт 390 сурагч суралцдаг ба Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хийсэн Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр улсдаа 1 дүгээр түвшинд, сургалтын чанараар 2 дугаар байранд орсон, сурагчдын сурлагын амжилт 100 хувиар үнэлэгдсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын бичиг баримт болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 86.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **71,933,511.10** | **116,876,274.91** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **9,004,425.10** | **57,707,712.91** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 9,004,425.10 | 57,707,712.91 |
| 31210 | Төгрөг | 9,004,425.10 | 57,707,712.91 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,701,993.10 | 54,739,980.91 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 4,302,432.00 | 2,967,732.00 |
| **33** | **АВЛАГА** | **81,052.00** | **81,053.00** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 81,052.00 | 81,053.00 |
| 33101 | Цалингийн авлага | 81,052.00 | 81,053.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **62,848,034.00** | **59,087,506.00** |
| 35100 | Түүхий эд материал | 29,360,313.00 | 29,476,855.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 29,037,213.00 | 29,187,755.00 |
| 35130 | Эм боох материал | 323,100.00 | 289,100.00 |
| 35400 | Хангамжийн материал | 33,487,721.00 | 29,610,651.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,012,850.00 | 197,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 27,624,851.00 | 27,182,051.00 |
| 35440 | Барилгын засварын материал | 216,250.00 | 134,600.00 |
| 35450 | Хүнсний материал | 4,633,770.00 | 2,096,700.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **239,897,728.56** | **263,972,561.59** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **239,897,728.56** | **263,972,561.59** |
| 39200 | Биет хөрөнгө | 231,075,728.56 | 255,150,561.59 |
| 39201 | Барилга, байгууламж | 214,701,885.04 | 214,701,885.04 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл-Барилга | (16,012,647.04) | (14,746,116.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 61,761,100.00 | 64,425,090.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл-Тоног төхөөрөмж | (33,217,388.12) | (23,225,926.76) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,035,966.60 | 20,022,153.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл-Тавилга | (12,508,374.90) | (8,631,869.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,965,600.00 | 2,865,300.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл-Бусад үндсэн хөрөнгө | (2,650,413.02) | (259,954,36) |
| 393 | Биет бус хөрөнгө | 8,822,000.00 | 8,822,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,822,000.00 | 8,822,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **311,831,239.66** | **380,848,833.50** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **-** | **6,256,953.00** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 6,256,953.00 |
| 41300 | Өглөг | - | 6,256,953.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 6,256,953.00 |
| 413203 | Түлш халаалтын өглөг | - | 6,256,953.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **311,831,239.66** | **374,591,880.50** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 311,831,239.66 | 374,591,880.50 |
| 51100 | ЗГ-ын оруулсан капитал /ЗГ-ын сан/ орон нутгийн сан | 89,261,526.00 | 89,261,526.00 |
| 511001 | Өмч: төрийн өмч | 89,261,526.00 | 89,261,526.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 124,100,565.76 | 191,067,815.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 113,333,260.27 | 128,307,174.45 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 10,767,305.49 | 62,760,640.84 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 98,469,147.90 | 94,262,539.21 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **311,831,239.66** | **380,848,833.50** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **301,289,632.00** | **445,213,527.60** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **19,998,932.00** | **39,441,427.60** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 19,998,932.00 | 39,441,427.60 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,302,432.00 | 250,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 4,302,432.00 | 250,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 15,696,500.00 | 37,792,177.60 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281,290,700.00** | **405,772,100.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 244,442,200.00 | 373,598,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 244,442,200.00 | 373,598,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 200,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 36,648,500.00 | 32,173,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 36,648,500.00 | 32,173,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **290,347,326.57** | **382,422,886.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **290,347,326.57** | **382,422,886.76** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 290,146,901.57 | 375,795,459.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 187,474,512.00 | 240,586,273.87 |
| 210101 | Үндсэн цалин | 139,961,125.00 | 186,635,547.06 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 36,636,902.00 | 43,398,647.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 879,000.00 | 1,440,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,997,485.00 | 9112,079.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл | 24,080,507.90 | 30,325,537.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,520,789.53 | 20,605,476.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,938,929.66 | 2,420,584.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,500,742.99 | 2,095,743.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 368,182.39 | 457,314.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,751,863.33 | 4,746,418.16 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,187,400.00 | 33,027,625.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,181,900.00 | 2,907,072.42 |
| 210302 | Түлш, халаалт | 23,573,500.00 | 29,830,553.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 432,000.00 | 290,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,457,605.00 | 8,345,258.00 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 1,715,800.00 | 733,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 784,100.00 | 729,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 1,005,000.00 | 1,715,600.00 |
| 210408 | Бараа материал актласны зардал | 952,705.00 | 5,166,708.00 |
| 2105 | Норматив зардал | 26,444,334.00 | 38,690,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 116,004.00 | 111,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,328,330.00 | 38,579,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,433,250.00 | 2,681,650.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,433,250.00 | 2,681,650.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 592,000.00 | 588,400.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 592,000.00 | 588,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,477,292.67 | 21,550,014.57 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,098,910.00 | 4,525,280.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 425,900.00 | 1,631,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 14,952,482.67 | 15,392,834.57 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 200,425.00 | 6,627,427.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 200,000.00 | 3,824,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 200,000.00 | 3,824,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 425.00 | 2,802,927.58 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 425.00 | 2,802,927.58 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **10,942,305.43** | **62,790,640.84** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **174,999.94** | **30,000.00** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | 174,999.94 | 30,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 174,999.94 | 30,000.00 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (6)=(4-5)** | **10,767,305.49** | **62,760,640.84** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **285,593,132.00** | **406,022,100.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 4,302,432.00 | 250,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 4,302,432.00 | 250,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 4,302,432.00 | 250,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 250,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 4,302,432.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **281,290,700.00** | **405,772,100.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 244,442,200.00 | 373,598,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 244,442,200.00 | 373,598,500.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,000.00** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 36,648,500.00 | 32,173,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 36,648,500.00 | 32,173,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **276,588,706.90** | **355,613,322.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **276,588,706.90** | **355,613,322.19** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 276,388,281.90 | 348,985,894.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 187,474,500.90 | 240,586,274.87 |
| 210101 | Үндсэн цалин | 141,706,821.38 | 186,635,548.06 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 35,282,194.57 | 43,398,647.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 879,000.00 | 1,440,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,997,484.95 | 9,112,079.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл | 23,770,571.00 | 30,325,537.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,198,300.00 | 20,605,476.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,905,717.00 | 2,420,584.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,511,054.00 | 2,095,743.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 377,764.00 | 457,314.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,777,736.00 | 4,746,418.16 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,187,400.00 | 26,770,672.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,181,900.00 | 2,907,072.42 |
| 210302 | Түлш, халаалт | 23,573,500.00 | 23,573,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 432,000.00 | 290,000.00 |
| 2105 | Норматив зардал | 27,665,150.00 | 36,042,330.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,665,150.00 | 36,042,330.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,343,900.00 | 2,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,343,900.00 | 2,600,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 592,000.00 | 588,400.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 592,000.00 | 588,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,963,760.00 | 12,072,680.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,206,110.00 | 10,308,380.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,757,650.00 | 1,764,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 200,425.00 | 6,627,427.58 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 200,000.00 | 3,824,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 200,000.00 | 3,824,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 425.00 | 2,802,927.58 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 425.00 | 2,802,927.58 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **9,004,425.10** | **50,408,777.81** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | | **1,705,490.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | 1,705,490.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | | 1,705,490.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 1,705,490.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | **(1,705,490.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **9,004,425.10** | **48,703,287.81** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **9,004,425.10** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **9,004,425.10** | **57,707,712.91** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | **89,261,526.00** | **98,469,147.90** | **113,333,260.27** | **301,063,934.17** |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 89,261,526.00 | 98,469,147.90 | 113,333,260.27 | 301,063,934.17 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 10,767,3055.49 | 10,767,3055.49 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **89,261,526.00** | **98,469,147.90** | **124,100,565.76** | **311,831,239.66** |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **89,261,526.00** | **98,469,147.90** | **124,100,565.76** | **311,831,239.66** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 4,206,608.69 | 4,206,608.69 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 89,261,526.00 | 98,469,147.90 | 128,307,174.45 | 316,037,848.35 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | (4,206,608.69) | - | (4,206,608.69) |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 62,760,640.84 | 62,760,640.84 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | **89,261,526.00** | **94,262,539.21** | **191,067,815.29** | **374,591,880.50** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 4,701,993.10 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 410,724,000.00 | 353,181,184.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 410,724,000.00 | 353,181,184.61 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 406,899,500.00 | 349,356,684.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 287,935,300.00 | 240,586,274.87 |
| 210101 | Үндсэн цалин | 192,320,700.00 | 186,635,548.06 |
| 210102 | Нэмэгдэл | 87,643,800.00 | 43,398,647.02 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | - | 1,440,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,970,800.00 | 9,112,079.79 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,991,700.00 | 30,325,537.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,474,400.00 | 20,605,476.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,879,200.00 | 2,420,584.81 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 2,303,600.00 | 2,095,743.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 575,700.00 | 457,314.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,758,800.00 | 4,746,418.16 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,573,600.00 | 26,770,672.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000,000.00 | 2,907,072.42 |
| 210302 | Түлш, халаалт | 23,573,600.00 | 23,573,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,000,000.00 | 290,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 37,131,700.00 | 36,042,330.00 |
| 210502 | Хоол хүнс | 37,131,700.00 | 36,042,330.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 2,600,000.00 | 2,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,600,000.00 | 2,600,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 588,400.00 | 588,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 588,400.00 | 588,400.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,078,800.00 | 12,443,470.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,313,700.00 | 10,679,170.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,765,100.00 | 1,764,300.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,824,500.00 | 3,824,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,824,500.00 | 3,824,500.00 |
| 3 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | |
| 30 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 4,701,900.00 | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 406,022,100.00 | 406,022,100.00 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 250,000.00 | 250,000.00 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 405,772,100.00 | 405,772,100.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 4,701,993.10 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 54,739,980.91 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 15.5 | 15.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.5 | 10.5 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,089.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,861.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 81.1 мянган төгрөгийн 1 зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж, 50.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 97.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

*Залруулсан алдаа:*

Аудитаар нийт 1,861.4 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,861.4 мянган төгрөгийн алдааг залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

*Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 228.1 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 50.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 81.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 97.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аж ахуйн материал дансанд бүртгэх бараа материалыг барилгын материал, бичиг хэргийн материалд бүртгэсэн | 1 | 1,426.6 | | | 1 | 1,426.6 | 1 | 1,426.6 | | | | |
| Нийгмийн даатгалаас авах листний мөнгийг үр дүнгийн тайлангийн орлогоор тусгасан | 1 | 13.9 | | | 1 | 13.9 | 1 | 13.9 | | | | |
| Цалингийн хүснэгтээрх тооцсон цалинг ерөнхий журналд дутуу тусгасан | 1 | 421.0 | | | 1 | 421.0 | 1 | 421.0 | | | | |
| **Дүн** | **1** | **1,861.5** | | | **1** | **1,861.5** | **1** | **1,861.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Албан томилолттой 1 албан хаагчид хоолны мөнгийг давхардуулан олгосон | 1 | 50.0 | 1 | 50.0 | | | | | | | | |
| Санхүүгийн тайлан дахь 81.0 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй | 1 | 81.1 | | | 1 | 81.1 | | | | | | |
| **Дүн** | **2** | **131.1** | **1** | **50.0** | **1** | **81.1** | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн. | 1 | 1,395.5 | | | | | 1 | 1,395.5 |
| Шилэн дансны орлого, зарлагын мэдээг 308,846.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | **2** | **1,395.5** | | | | | **2** | **1,395.5** |

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 22 өдөр Дугаар 120 Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитаар санхүүгийн тайлан дахь 81,053.00 /наян нэгэн мянга тавин гурав/ төгрөгийн байгууллагаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*/, мөн хуулийн 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллага, хувь хүмүүстэй авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулан санхүүгийн тайланд тусгах;
2. Дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Х.Эрдэнэтуяа), нягтлан бодогч (Н.Саранзаяа) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**
АУДИТОР /М.МӨНХЗУЛ/

**БАТАЛГААЖУУЛСАН:**
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Р.МӨНХТОГТОХ/

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 22 өдөр Дугаар 44 Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

1. Аудитаар албан томилолттой 1 албан хаагчид 50,000 төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т /*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*/, 20.2.3-д /*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*/, Монгол улсын Сангийн сайдын 2020 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаалын 1-д /*Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг сумандд 24,000 төгрөг,...., байрны зардлыг 40,000 төгрөг ...... тус тус шинэчлэн баталсугай.*/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т /Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно./, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 -т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон албан томилолтын 50,000 /*Тавин мянган*/ төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх;

Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Х.Эрдэнэтуяа, Нягтлан бодогч Н.Саранзаяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АХЛАХ АУДИТОР М.МӨНХЗУЛ

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113